



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2023 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан нийт 2,514,079,492.00 (хоёр тэрбум таван зуун арван дөрвөн сая далан есөн мянга дөрвөн зуун ерэн хоёр) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Төрхүү нарт тус тус дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, байнгын ашиглалтад хүлээн авч, бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ
123007603
4-r huraldaan.docx

мичийн бодлого, зохицуулалт
ы 02 дугаар сарын 06 - н
...48 дугаар тогтролын

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /төгрөгөөр/	Улсын комиссын актын дугаар
1	Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн конторын барилга /Хэнтий аймаг, Хэрлэн сум, 3-р баг/	3 давхар, зоорьтой, нийт 916м2	2,514,079,492.00	2023 110/2023
	Нийт дүн		2,514,079,492.00 (хоёр тэрбум таван зуун арван дөрвөн сая далан есөн мянга дөрвөн зуун ерэн хоёр)	

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /төгрөгөөр/	Улсын комиссын актын дугаар
1	Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн конторын барилга /Хэнтий аймаг, Хэрлэн сум, 3-р баг/	3 давхар, зоорьтой, нийт 916м2	2,514,079,492.00	2023 110/2023
	Нийт дүн		2,514,079,492.00 (хоёр тэрбум таван зуун арван дөрвөн сая далан есөн мянга дөрвөн зуун ерэн хоёр)	